



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 9 сарын 24 өдөр

Дугаар 4/200

Улаанбаатар хот

Ус судлалын харуулыг шилжүүлэн
ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгсий голын голдирол өөрчлөгдсөнтэй холбогдуулан Хөвсгөл аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн харьяа "Бүгсий-Төмөрбулаг" ус судлалын харуулыг өргөргийн $49^{\circ}17'23.53129''$, уртрагийн $100^{\circ}13'15.77284''$ солбилцолд шилжүүлж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн батлагдсан хөтөлбөрийн дагуу ажиллуулахыг Хөвсгөл аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Б.Өнөрбат)-д үүрэг болгосугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын сүлжээний хэлтсийн дарга (Д.Уламбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

151250604